



**ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 61183

Улаанбаатар хот

Сувиллын хөнгөлөлт олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан "2019-2020 оны Хамтын гэрээ"-ний 5.7 дахь заалт, ажилтны өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймгийн "Шаргалжуут" рашаан сувилалд 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл 10 хоног сувилуулсан Захиргаа удирдлагын хэлтсийн сургалтын ахлах мэргэжилтэн Цэдэндамбын Эрдэнэбат /100170/-д 200000 /Хоёр зуун мянга/ төгрөг, Өвөрхангай аймгийн "Хужирт" рашаан сувилалд 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл 7 хоног сувилуулсан Турбин-хими цехийн турбины ахлах машинч Цэнд-Аюушийн Мөнхзаяа /100118/-д 140000 /Нэг зуун дөчин мянга/ төгрөгийн сувиллын хөнгөлөлтийг тус тус олгосугай.

2. Сувиллын хөнгөлөлтөд олгох 340000 /Гурван зуун дөчин мянга/ төгрөгийг ажилчдын нийгмийн эрүүл мэнд, сувиллын хөнгөлөлтийн зардлаас тооцохыг Санхүү бүртгэл, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Б.Даваадулам/-д зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



С.БЯМБААХҮҮ

Tushaal.2019

360000857